

АЖ ҮЙЛДВЭР, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн салбар чухал байр суурь эзэлдэг бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 25–30 орчим хувийг бүрдүүлж байгаа хэдий ч үйлдвэрлэлийн ихэнх нь эрдэс баялгийн олборлолт, анхан шатны боловсруулалт зэргээс хамаарч байна.

Иймээс нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд анхаарч зэс, ган, нүүрс-хими, кокс-хими, алт цэвэршүүлэх үйлдвэрийн төслүүдийг урагшлуулах, үйлдвэрлэл, технологийн парк хэлбэрээр барьж байгуулан хөгжүүлэх нь нэн шаардлагатай асуудал болж байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Гангийн цогцолбор, Газрын тос боловсруулах цогцолбор, Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулан ашиглалтад оруулах зэрэг мега төслүүд нь аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт тэр дундаа хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих төслүүд байгаа бөгөөд үндсэн зорилго, зорилтын хүрээнд дараах цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг 12 байршилд үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр байгуулж хөгжүүлэхээр төлөвлөн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасны дагуу “паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт”-ыг Засгийн газрын 2024 оны 204 дүгээр тогтоолоор баталсан.

Төлөвлөөд байгаа 12 паркаас төрийн өмчит “Дархан” гангийн цогцолбор, “Эрдэнэт” зэс боловсруулах цогцолбор, “Тавантолгой” кокс химийн цогцолбор, “Багануур” нүүрс-химийн цогцолбор, “Бор-Өндөр” жонш, цахиур боловсруулах цогцолбор, “Хөтөл” барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор, орон нутгийн өмчит “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк”, “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк”, хувийн өмчит “Ховд” үйлдвэрлэл, технологийн паркууд нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хөгжлийн төлөвлөгөө, нэгжийн техник эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зэрэг хуулиар шаардсан баримт бичгүүдийг бүрдүүлэн ажиллаж байгаа бол хувийн өмчит “Инфинити спейс” ХХК-ийн “Алтан ширээт” үйлдвэрлэл, технологийн парк, “Си Өү Эй Эл” ХХК-ийн “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркууд нь Засгийн газрын 2023 оны 267 дугаар тогтоолоор 15 жилийн хугацаатай олгосон паркийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Инфинити спейс” ХХК-тай Засгийн газрын 2024 оны 191 дүгээр

тогтоолын дагуу, “Си Өү Эй Эл” ХХК-тай Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтоолын дагуу “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх” гурван талт гэрээг тус тус байгуулан паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа нийт 2100 орчим нэр төрлийн бараа материалын 110 орчим тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгаж, паркуудын удирдлага, нэгжүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн 52.3 тэрбум төгрөгийн бараа материал гаалийн албан татвараас чөлөөлөгдөх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хүнд үйлдвэрийн салбар хөгжихийн хэрээр уул уурхайн түүхий эдийн гаралт давамгайлсан бүтэцтэй эдийн засгаас, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд аажмаар шилжих суурь нөхцөл бүрдэж байна. Үүний үр дүнд экспортын чиг баримжаа бэхжиж, импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэх, уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бууруулах, боловсруулах үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нэмэгдэх хандлага бий болж байна. Мөн эдийн засгийн үр өгөөж, татварын орлого, санхүүгийн бааз суурь тэлж, валютын ханшийн тогтвортой байдал сайжрах, орон нутагт ажлын байр олноор нэмэгдэх, хот суурин газарт хүн амын хэт төвлөрлийг сааруулах зэрэг эдийн засаг, нийгмийн олон талын ач холбогдолтой бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн бодит үр нөлөөтэй.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь (2015-2024 он)



Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн нэгдсэн мэдээллийн сан (1212.mn)

Монголын Улсын боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2015–2020 онд харьцангуй тогтвортой, өсөх хандлагатай байсан бөгөөд 2020 онд оргилдоо (9.18%) хүрсэн. Энэ өсөлт нь тухайн үед аж үйлдвэрийн дотоодын үйлдвэрлэл идэвхжиж, уул уурхайн бүтээгдэхүүний дотоод боловсруулалт тодорхой хэмжээнд нэмэгдэн, COVID-19 цар тахлын үед импорт багасч, дотоодын үйлдвэрлэл харьцангуй эрэлттэй байсантай холбоотой.

Харин 2021 оноос хойш салбарын хувь хэмжээ аажмаар буурч, ялангуяа 2023–2024 онд огцом буурсан (7.34% → 6.61%) нь түүхий эдийн экспорт давамгайлсан бүтэц хадгалагдсан, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл хөгжөөгүй, валютын ханш, логистик, санхүүжилтийн дарамт зэрэг бүтцийн асуудлууд үргэлжилж байгааг харуулж байна.

Иймд нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих нь дотоодын нийт бүтээгдэхүүний тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг бодитоор хэрэгжүүлэх стратегийн чухал ач холбогдолтой юм.

---o0o---